



Date 2020.08.25

No 2/648

Ulaanbaatar


ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Ганбаатар овогтой Мөнхтуяа би "Сөүл Сэниорс Товер" ХХК (цаашид Компани гэх)-ийн Гүйцэтгэх захирлын хувьд, Түвшинширээ овогтой Номин би тус Компанийн Санхүүгийн Захирлын хувьд ард хавсаргасан 1-ээс 34-р хуудас дахь "Сөүл Сэниорс Товер" ХХК-ийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Компанийн санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Г. МӨНХТУЯА
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т. НОМИН
САНХҮҮГИЙН ЗАХИРАЛ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Сөүл Сэниорс Товер ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа:

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

Дүгнэлт

Бид Сөүл Сэниорс Товер ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ийн дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд санхүүгийн тайлан болон аудиторын тайланд ороогүй компанийн жилийн тайланд агуулагдсан мэдээллүүд багтдаг.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед нь унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бидний хийсэн ажил дээр үндэслэхэд энэхүү бусад мэдээлэлд материаллаг хэмжээний буруу илэрхийлэл байна гэж бид дүгнэвэл тус баримтыг тайлагнах шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор тайлагнах зүйлс бидэнд байхгүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Делоитт нь Нэгдсэн Вант улсад анх үүсгэн байгуулагдсан Делоитт Түш Тохмацу Лимитед (ДТТЛ) болон түүний гишүүн байгууллагууд, харьяа компаниудаас бүрдэнэ. ДТТЛ болон түүний гишүүн компаниуд нь бие даасан хуулийн этгээдүүд байх бөгөөд үйл ажиллагааны хувьд хараат бус байна. ДТТЛ (мөн "Делоитт Глобал" гэх) нь харилцагчдад үйлчилгээ үзүүлдэггүй. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.deloitte.com/about цахим хуудаснаас авна уу.

Делоитт нь аудит, консалтинг, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, эрсдэлийн удирдлага, татвар болон холбогдох чиглэлээр төрөл бүрийн салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Делоитт Онч ХХК болон түүний охин компаниуд нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө үзүүлэх мэргэжлийн үйлчилгээгээр дамжуулан Монголын харилцагчдад мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Делоиттын олон улсын сүлжээний гишүүн байгууллага юм.

**СӨҮЛСЭНИОРС ТОВЕР ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2019 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2019	2018
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	6,614,095	3,311,207
Хугацаатай хадгаламж	6	2,590,553	2,177,534
Дансны болон бусад авлага	7	698,959	742,903
Бараа материал	8	1,277,109	1,589,643
Урьдчилгаа төлбөр		138,646	162,409
		11,319,362	7,983,696
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	28,767,240	28,258,458
Биет бус хөрөнгө	9	142,332	160,625
Хойшлогдсон татварын хөрөнгө	13.3	340,218	314,271
		29,249,790	28,733,354
		40,569,152	36,717,050
НИЙТ ХӨРӨНГӨ			
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	11	2,014,261	1,173,027
Орлогын албан татварын өглөг	13.2	429,700	237,133
Холбоотой талаас авсан зээл	18.1	10,791,701	10,148,419
Нийт өр төлбөр		13,235,662	11,558,579
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	12	8,000,000	8,000,000
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц		20,168,610	20,168,610
Хуримтлагдсан алдагдал		(835,120)	(3,010,139)
Нийт эздийн өмч		27,333,490	25,158,471
		40,569,152	36,717,050
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.